



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД
С.ОДОНТУЯА ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: somcog@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2025. 01. 13 № 01/640.
танай _____ -ны № _____ -т

Зөвлөмж хүргүүлэх тухай


Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг удирдамжийн дагуу авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг арилгах, төрийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээнд тандалт хийх, хүнд суртал чирэгдэл үүсгэж байгаа эсэх, ил тод байдлыг хангуулах зорилгоор Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд ажиллахад дараах нөхцөл байдал тогтоогдов. Тухайлбал,

Хөдөлмөрийн дотоод журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаггүй, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлдэггүй, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, гомдол мэдээлэл, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэдэггүй, байгууллагын төсвийн төлөвлөгөөг боловсруулахдаа үндсэн үйл ажиллагааны орлогыг жил бүр дутуу төлөвлөдөг, эрх олгоогүй байхад тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан, үйл ажиллагааны мэдээлэл нь олон нийтэд нээлттэй, ил тод бус байгаа зэрэг нь төрийн байгууллагын хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчлийг үүсгэж болзошгүй байх тул дараах "Зөвлөмж"-ийг хүргүүлж байна.

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, биелэлт, үр дүнгийн талаарх хариуг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт 9 хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



З.ДАШДАВАА

142503000458

1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30 31 32 33 34 35 36 37 38 39 40 41 42 43 44 45 46 47 48 49 50 51 52 53 54 55 56 57 58 59 60 61 62 63 64 65 66 67 68 69 70 71 72 73 74 75 76 77 78 79 80 81 82 83 84 85 86 87 88 89 90 91 92 93 94 95 96 97 98 99 100

.....

.

1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30 31 32 33 34 35 36 37 38 39 40 41 42 43 44 45 46 47 48 49 50 51 52 53 54 55 56 57 58 59 60 61 62 63 64 65 66 67 68 69 70 71 72 73 74 75 76 77 78 79 80 81 82 83 84 85 86 87 88 89 90 91 92 93 94 95 96 97 98 99 100

REPRODUCTION

Авлигатай тэмцэх газрын
2025 оны 01 дүгээр сарын 13 ны өдрийн
01/64 дугаар албан бичгийн хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖ

Зөвлөмж 1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, тогтмол хяналт тавих.

Нөхцөл байдал:


Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны албан тушаалтнууд албан үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, тайлбарыг гаргаагүй байна. Тухайлбал, тус хамгаалалтын захиргааны даргын 2023.12.15-ны өдрийн А/65 дугаартай “Төсөв зарцуулах тухай” тушаалаар албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон байх ба тус байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга, нягтлан бодогч нар нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-т “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасныг зөрчиж өөртөө олгосон байна.

Дээрх албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор гаргасан тушаалаар нэг ажилтанд буцалтгүй тусламж болгон 3,4 сая төгрөг буюу нийт 22 хүнд 74,8 сая төгрөгийг олгосон, тухайн үед 23 хүн ажиллаж байсан ба хамт олны хуралд 17 хүн оролцож, 10 хүн гарын үсэг зурж баталгаажуулсан нь Сангийн сайдын 2022.12.30-ны өдрийн А/282 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 1.3.3-т “*шийдвэр гаргах, тайлагнах, хяналт тавихад байгууллагын нийт хамт олны оролцоог хангах*”, Горхи-Тэрэлжийн хамгаалалтын захиргааны Хөдөлмөрийн дотоод журмын 8.21-т “*тусламж, тэтгэмж, дэмжлэг, олговор олгох, хэмжээг нэмэгдүүлэх, ажилтны болон нийт ажилтны нийгмийн асуудлыг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх ба шаардлагатай гэж үзвэл нийт ажилтны хурлаар хэлэлцүүлж, хамгаалалтын захиргааны даргын тушаалаар шийдвэрлэнэ*” гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж 2. Төрийн байгууллагын ил тод байдлыг хангуулах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх, удирдлагын хяналтыг сайжруулах.

Нөхцөл байдал:

Тус байгууллагын албан ёсны <http://gorkhi-terelj.mpa.gov.mn/> цахим хуудсанд үнэлгээ хийхэд 100%-иас 7.3% буюу ил тод байдал хангалтгүй байна. Тухайлбал, шилэн данс, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, хүний нөөц, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хууль тогтоомжийн талаарх мэдээллийг байршуулаагүй байгаа нь



олон нийтэд тусгай хамгаалалттай газар нутагт эрхлэх үйл ажиллагаа, газар ашиглах, нэвтрэх төлбөр, хураамжийн талаарх мэдээлэл хязгаарлагдмал гэж үзэхээр байна.

Хамгаалалтын захиргаа нь 2023 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 767 албан бичиг хүлээн авсан байх ба албан бичгийн хариуг 9-54 хоногоор хоцроож шийдвэрлэсэн, иргэний гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаарх ажиллагааны баримт материалыг бүрдүүлдэггүй, архивын нэгж үүсгэдэггүй зөрчил тогтоогдов. Тухайлбал, 2024 оны гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн байдлыг судлан үзэхэд мэргэжилтэн Ч.Сийлэгмаад 5, Т.Эрдэнэбаярт 1, Ц.Оюунцэцэгт 31, Н.Батболд 1 гомдол тус тус цохогдсон байх ба шийдвэрлэлт тодорхойгүй, цахим программын асуудлаас үүдэн мэргэжилтэн Ц.Оюунцэцэгийн шийдвэрлэсэн "газрын төлбөрийн үлдэгдэлтэй холбоотой 6 гомдлыг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас цахим санд хаалт хийж болохгүй байсан" байна.

Иймд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлээгүй, иргэн, аж ахуйн нэгжээс гаргасан хүсэлтийн хариуг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлэж ажиллаагүй албан хаагч нарт болон хяналт тавьж, удирдлага, арга зүйгээр хангах чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга М.Эрдэнэбулган нарт зохих хариуцлага ногдуулах, тухайн байгууллагад өргөдөл, гомдол хүлээн авах, шилжүүлэх, шийдвэрлэх, тайлагнах, хариуг өгөх үйл ажиллагааг журамлах, архивын бичиг баримтын бүрдүүлбэрийг ханган баримтжуулдаг байх шаардлагатай байна.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын 2023-2024 оны А, Б тушаал шийдвэр, ирсэн, явсан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт зэргийг судлан үзэхэд Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 2.2.2.1-т "албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, баримт бичгийн стандартыг өөрийн хариуцсан нэгжийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих", 2.2.2.2-т "хариуцсан нэгжид ирсэн, аливаа баримт бичгээр тавигдсан асуудлын шийдвэрлэлтийн явц, үр дүнг хянах" гэж заасныг хэрэгжүүлээгүй нөхцөл байдал тогтоогдсон. Тухайлбал, албан бичиг, тушаал, шийдвэрийг боловсруулсан, хянасан ажилтан тодорхойгүй, нэг тушаалыг давхардуулж гаргасан, тушаалын дугаар, хугацааг зөрүүтэй олгож бүртгэсэн, албан хаагчдын төлөвлөгөө, тайлан, хурлын тэмдэглэлийг архивлаагүй, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хамгаалалтын захиргааны дарга хянаж, үнэлгээ хийсэн эсэх нь тодорхойгүй байв.

Зөвлөмж 3. Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх төлбөр авах үйлчилгээнд хяналт тавих, цахимжуулах талаар эрх зүйн орчныг бий болгоход чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Нөхцөл байдал:

Горхи-тэрэлжийн байгалийн цогцолборт газарт нэвтрэх төлбөрийн цахим төхөөрөмжийг 2023 оны 06 дугаар сард суурилуулж, 2023.07.01-ний өдөр хүртэл тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамжийг цахимаар хурааж эхэлсэн ч, цахимаар үүссэн нэхэмжлэхийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд сайн дураараа төлдөггүй, нөхөн төлүүлэх хуулийн зохицуулалт байхгүй тул нэвтрэх төлбөрийн хураамжийг 2024 оны 04 дүгээр сараас эхлэн буцаад тасалбараар олгож эхэлсэн байна.



Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх төлбөр хураамжийн үйл ажиллагааг судлан үзэхэд Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт нэвтрэх хураамжийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авахдаа Худалдаа хөгжлийн банкны ПОС машиныг ашигладаг бөгөөд иргэдийн бэлнээр төлсөн хураамжийг тухайн үүрэг гүйцэтгэж буй тасалбар түгээгүүрийн кассчин хуримтлуулан, өөрийн хувийн дансаар дамжуулан төрийн сангийн данс руу нэгтгэн шилжүүлдэг нь авлигын гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэлтэй нөхцөл байдлыг бий болгож байна.

Иймд нэвтрэх хураамжийг Зам тээврийн хөгжлийн төвийн төлбөр хураах систем, "Е-Монголиа" цахим системд холбож нэхэмжлэхийн дагуу төлдөг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, мөн үндсэн үйл ажиллагааны орлогын дүнг бодитой тооцоолоход чухал ач холбогдолтой байх тул цаашид цахим төлбөр авах төхөөрөмжийг зайлшгүй нэвтрүүлэх нь зүйтэй байна.


Зөвлөмж 4. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны төсөв, орлого төлөвлөлт, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх.

Нөхцөл байдал:

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны санхүүгийн тайланг судлан үзэхэд 2023 онд төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 832,9 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 734,9 сая төгрөгийн төвлөрүүлж, үндсэн үйл ажиллагааны орлого 41,5 сая төгрөг төвлөрүүлэхээс 43,6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байсан. Харин 2022 онд үндсэн үйл ажиллагаанаас олох орлогыг мөн адил 41,5 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 53,9 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Гэтэл 2022 онд давсан орлогын үлдэгдэлгүй байхад 2023 оны давсан орлогын тайланг үзэхэд 157,4 сая төгрөгийг төвлөрүүлсэн гэж тайлагнасан, 2024 онд үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй боловч хагас жилийн гүйцэтгэлээр 168,1 сая төгрөгийг төвлөрүүлсэн гэж тайлагнасан нь тус байгууллага үндсэн үйл ажиллагааны орлогыг дутуу төлөвлөж, улсын төсвөөс авах санхүүжилтийг хэмнэх боломжтой байхад жил бүр тогтсон мөнгөн дүн төлөвлөж, орлогыг нуун дарагдуулж байна гэж үзэхээр байна. Тухайлбал, тусгай хамгаалалтын бүсээр нэвтрэх хураамжийн тасалбарыг 2023 онд санхүүгийн программд "үнэт цаас" гэсэн цонхонд бүртгэдэг байсан бол одоо ашиглаж байгаа "Си ти эс" санхүүгийн программд "хүнсний материалын данс" гэсэн цонхонд бүртгэж байна. Тус байгууллагын 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланд хүнсний материалын үлдэгдэл мөнгөн дүн 3,9 сая төгрөг байхад жилийн эцсийн үлдэгдэл нь 68,7 сая төгрөг буюу хүнсний материалын өссөн мөнгөн дүн болох 64,8 сая төгрөг нь үнэт цаасны төлбөр байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас үнэт цаас (тасалбарыг) шинээр хэвлэж тусгай хамгаалалттай газрын захиргаанд түгээсэн тул Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд хуучин тасалбар болох ширхэг нь 3000 төгрөгийн үнэ бүхий 50.000 ширхэг, нийт 150,0 сая төгрөгийн тасалбарыг одоо үйл ажиллагаанд ашиглах боломжгүй хэмээн хадгалж байгаа нь төрийн өмчийг үр ашиггүй зарцуулсан гэж үзэж болохоор байна.

1/ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хөрөнгө оруулалтын багцын VI.2.1 "...Хамгаалалтын захиргааны барилгын засвар төсөл, арга хэмжээ" 359,4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргад А/38 дугаар тушаалаар эрх шилжүүлсэн ажлыг Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын газар эрх шилжүүлээгүй байхад зохион байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн



хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7-д “Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ” гэснийг хэрэгжүүлээгүй.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэлээс 2024.07.05-ны өдрийн 03/3255 дугаартай албан бичгээр “дээрх засварын ажлын тендерийг зохион байгуулсан бол хүчингүй болгох, цуцлах” чиглэл өгсөн байхад “Евро Урлан” ХХК-ийг шалгаруулж, 2024.05.27-ны өдрөөс 2024.08.03-ны өдрийн хугацаатай холбогдох гэрээг байгуулан, засварын ажлыг шууд эхэлсэн байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга нь 2024.08.26-ны өдрийн 03/3960 дугаартай албан бичгээр “дээрх тендерийг зохион байгуулах”-ыг зөвшөөрч, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга М.Эрдэнэбулганы 2024.05.27-ны өдөр байгуулсан №БОАЖЯ/20240101032 дугаартай гэрээг засварын ажлын тендерт шалгарсан “Евро урлан” ХХК-тай 2024.10.08-ны өдөр дахин байгуулсан байна. Төрийн нарийн бичгийн даргын №БОАЖЯ/20240101032 дугаартай гэрээг дахин байгуулах үед тухайн засварын ажил дуусч байв.

Тус байгалийн цогцолборт газрын хамгаалалтын газрын гэрээний хэрэгжилтэд тандалт хийхэд нэгдсэн бүртгэл, дугаар олголт байхгүй, 4-5 ажилтан гэрээ байгуулсан байх боловч гэрээний төслийг хуулийн ахлах ажилтан хянадаггүй, архивын бүрдлийг хангаагүй, холбогдох баримт бичгийн эмх цэгцгүй нөхцөл байдал нь Засгийн газрын 2020 оны 246 дугаар тушаалаар баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.5.2-т “Гэрээ, хэлэлцээр, санамж бичгийг ажил үүргийн дагуу хариуцсан ажилтан оны эхнээс дугаарлан бүртгэл хөтөлж, мэдээллийн сан үүсгэсэн байна.”, 3.5.3-т “Гэрээний бүртгэл, хяналтыг хууль эрх зүйн асуудал хариуцсан нэгж (ажилтан), байхгүй бол захиргааны асуудал хариуцсан нэгж (ажилтан) хариуцна.”, 3.7.2-т “Байгууллагын үйл ажиллагааны явцад баталж мөрдүүлж байгаа зохион байгуулалт, мэдээлэл-лавлагааны баримт бичгүүдийг заавал бүртгэсэн байна” гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлээгүй, удирдлагын хяналт хангалтгүй байна.

Иймд дээрх эрсдэлээс урьдчилан сэргийлж, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны төсөв, санхүү, төсвийн зарцуулалтад төрийн аудитын байгууллагаар хяналт шалгалт хийлгэх ажлыг 2025 оны эхний улиралд багтаан хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Зөвлөмж 5. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаанаас иргэн, аж ахуйн нэгжийн газар ашиглах эрхийг сунгах, цуцлах, хүчингүй болгох, солбицолд өөрчлөлт оруулсан нөхцөл байдлаар хэлэлцүүлэг зохион байгуулах, зарим чиг үүргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу яам хариуцах, тухайн үйл ажиллагаанд мөрдөх журам, заавар, удирдамж, стандартыг батлан мөрдүүлэх.

Нөхцөл байдал:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/151 дугаар тушаал “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах, журам батлах тухай”-ын нэгдүгээр хэсэгт “Тусгай



хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаанаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар ашиглах эрхийг сунгах, цуцлах, хүчингүй болгох, солбицолд өөрчлөлт оруулах саналыг яаманд ирүүлэх” гэж тусгаснаар Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны холбогдох ажилтан дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлж, саналыг яаманд уламжилдаг байна.

Уг санал хүргүүлэх албан бичигт иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар ашиглах эрхийг сунгах, цуцлах, хүчингүй болгох, солбицолд өөрчлөлт оруулах нөхцөл шалтгаан, дүгнэлт гаргасан баримт хавсаргаагүй байх бөгөөд цахим мэдээллийн санд газрын солбицол нэмэх хасах хөдөлгөөнийг бүртгэж оруулж байгаа ч өгөгдлийг хянах, лог бүртгэх ажлын тухай мэдээлэлгүй, түүнд тавих хяналт байхгүй байв.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/151 дугаар тушаал “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах, журам батлах тухай”-ын Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга орсон байх бөгөөд хамгаалалтын захиргаанаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар ашиглах эрхийг сунгах, цуцлах, хүчингүй болгох, солбицолд өөрчлөлт оруулахаар уламжилсан саналыг хэлэлцэн батлахад мөн өөрөө оролцож байгаа нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөлийг бүрдүүлж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.11-д “тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, хэрэгжилтийг хангах”, 36 дугаар зүйлийн 36.1-д “Төрийн захиргааны төв байгууллага дархан цаазат газрын хязгаарлалтын бүс болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг энэ хуулийн 27 дугаар зүйлийн 12-т заасан сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн гаргана”, 27 дугаар зүйл “Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх”-ийн 2 дугаарт “тусгай хамгаалалттай газар нутагт явуулах судалгаа, шинжилгээний ажлын журам, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, зөвшөөрөл олгох, холбогдох тайлан, мэдээллийг авч нэгдсэн санд оруулах” гэж заасан байхад доор дурьдсан үйл ажиллагаа нь хууль тогтоомжийг нэг мөр мөрдөхгүй байгаатай холбоотой байна.

Дээрх журмын дагуу хэрэгжүүлж байгаа зарим үйл ажиллагаанд тандалт хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдов. Үүнд:

Усан сан буюу ойн сан бүхий газартай давхцалтай хэсгийг хасаж, солбицол өөрчлөх болон талбай нэмэх хүсэлтийг уламжилсан 2023 онд “Атар шим трейд” ХХК, “Баянхайрхан амин” ХХК, “Структурист” ХХК, “Баянгүр лэнд” ХХК, “Отгон чандмань уул” ХХК зэрэг нийт 5 аж ахуйн нэгж, Ц.Ариунзул гэх 1 иргэний хүсэлтийг яаманд уламжилсан байх боловч өөрчлөөгүй, хэмжээг багасгасан 7 иргэн болон аж ахуйн нэгж байна. Харин талбай нэмэх хүсэлт хүргүүлж, 2024 онд дараах иргэдэд газрын хэмжээг нэмэгдүүлсэн байна.

Тухайлбал, “Улаанбаатар зочид буудал” ХХК-ийн 22 га газрыг 31.4 га болтол 2 удаа (энэ онд 94000 м2), иргэн Б.Батсуурийн 2.0 га газрыг 27.6 га болгон 2023 онд **256000-гаар** (2007-08-07 00:00:00, 2020-05-18 14:26:09, 2023-01-17 15:40:00, 2023-08-17 16:54:00), иргэн Д.Оюунчимэгийн 1.0 га газрыг 40000 м2, “Таскания трейдинг” ХХК-ийн 1 га газрыг 43019 м2 тус бүр нэмэгдүүлсэн.

Талбайг өөрчлөх санал хүргүүлсэн судалгааг хүснэгтээр харуулбал:

1945
1946
1947
1948
1949

1945
1946
1947
1948
1949

1950
1951
1952
1953
1954

1950
1951
1952
1953
1954

1955
1956
1957
1958
1959
1960

1955
1956
1957
1958
1959
1960

1961
1962
1963
1964
1965
1966

1961
1962
1963
1964
1965
1966

1967
1968
1969
1970
1971
1972

1967
1968
1969
1970
1971
1972

1973
1974
1975
1976
1977
1978

1973
1974
1975
1976
1977
1978

1979
1980
1981
1982
1983
1984

1979
1980
1981
1982
1983
1984

Талбайн хэмжээг өөрчлөлтийн судалгаа тоо, хувиар					
№	Огноо	Хэмжээг нэмсэн	Хэмжээг хассан	өөрчлөгдөөгүй	Нийт
1	2023	13 /48.1%/	7 /25.9%/	7 /25.9%/	27
2	2024	23 /47.9%/	25 /52.0%/	-	48
Нийт					75

Усан сан буюу ойн сан бүхий газартай давхцалтай хэсгийг хасаж, солбицол өөрчлөх болон талбай нэмэх хүсэлтийг уламжилсан байх бөгөөд 2024 онд газрын хэмжээг багасгасан тохиолдол байхгүй, харин нэмэгдүүлсэн 36 иргэн, аж ахуйн нэгж байгаагаас "Вин вин" ХХК-ийн 2 га газрыг 3 удаагийн нэмэлтээр 2024 онд 60246-аар, "Гайхалтай тур" ХХК-ийн 3.0 га газрыг 23093-аар, "Эл-Эзэн" ХХК-ийн 19983 м² газрыг 25281-ээр, "Амантокта" ХХК-ийн 1.5 га газрыг 17116.4-өөр, "Эвтсан" ХХК-ийн 2.0 га газрыг 551843-аар, "Бундхорол тур" ХХК-ийн 2.0 га газрыг 23748.7-оор, "Горхийн чулуу" ХХК-ийн 2.0 га газрыг 266778-аар удаа дараа нэмэгдүүлэн олгосон байгааг хянуулахаар Авлигатай тэмцэх газрын холбогдох нэгжид шилжүүлээ.

Газрын хэмжээг нэмэгдүүлж буй зарим үйл ажиллагаанд зөрчил гаргасан аж ахуйн нэгжийн газрыг (Жишээ нь: "Гайхалтай тур" ба "Вин вин констракшн" ХХК) сунгах болон солбицол нэмэгдүүлсэн тохиолдол нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.3-т "батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсвийг зөрчиж суурингийн нутаг дэвсгэрийг тэлэх, барилга байгууламж барих" гэсэн заалтын хэрэгжилтэд яамны тавих хяналт хариуцлагын тогтолцоо хангалтгүй байгааг харуулж байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ойн болон усан сан бүхий газартай давхцалтай хэсэг өөрчлөлт ороогүй тохиолдол 2023 онд 7 буюу 25.9 хувьтай, газрын хэмжээг багасгасан тохиолдол 2023 онд 7 буюу 25.9 хувьтай, 2024 онд 25 буюу 52.0 хувьтай, харин нэмэгдүүлсэн нь 2023 онд 23 буюу 47.9 хувьтай, 2024 онд 25 буюу 52.0 хувьтай байна.

Дээрх тоон мэдээлэлд үндэслэн анх авсан газрын хэмжээг удаа дараа нэмэгдүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн газрын хэмжээг кадастр бүхий зураглалаар, зөвшөөрөл өгсөн ажлын хэсэг, албан тушаалтан бүрээр улсын хэмжээнд сүүлийн 10 жилээр судалгааг хийж хэлэлцүүлэг зохион байгуулан, цаашид авах арга хэмжээг тодорхойлох нь зүйтэй байна.

Зөвлөмж 6. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/151 дүгээр "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах, журам батлах тухай" тушаалыг хүчингүй болгох, хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх ажлыг зохион байгуулахдаа Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг хэрэгжүүлэх.

Нөхцөл байдал:

Ажлын хэсэг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/151 дүгээр "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах, журам батлах тухай" тушаалыг хянан үзэж, дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдов. Үүнд:

Журмын 1 дүгээр хэсэгт "Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаанаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар ашиглах эрхийг сунгах, цуцлах, хүчингүй болгох, солбицолд өөрчлөлт оруулах саналыг

1950
1951
1952
1953
1954
1955
1956
1957
1958
1959
1960

UNITED STATES DEPARTMENT OF AGRICULTURE
OFFICE OF THE SECRETARY

Washington, D. C.
20250
Telephone: 447-1111
Telegrams: AGRICULTURE
Teletype: 447-1111
Radio: 447-1111
Cable: 447-1111

For information of the public,
the following information is
being furnished to you
for your information.

Very truly yours,
Secretary

1950
1951
1952
1953
1954
1955
1956
1957
1958
1959
1960

яаманд ирүүлэх” гэж заасан нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйл “Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх”-ийн 2 дугаарт “тусгай хамгаалалттай газар нутагт явуулах судалгаа, шинжилгээний ажлын журам, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, зөвшөөрөл олгох, холбогдох тайлан, мэдээллийг авч нэгдсэн санд оруулах” гэж заасантай нийцэхгүй байна. Тухайлбал,

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/151 дугаар “Ажлын хэсэг” шинэчлэн байгуулах, журам батлах тухай” тушаалыг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар ашиглах эрхийг сунгах, цуцлах, хүчингүй болгох, солбицолд өөрчлөлт оруулах саналыг тус яаманд хүргүүлээд, холбогдох албан тушаалтны шийдвэр гарсны дараа иргэн, аж ахуй нэгж нь баримт бичгийг авч ирсэн үед цахим мэдээллийн санд газрын солбицол нэмэх хасах хөдөлгөөнийг бүртгэж оруулдаг байна. Харин тухайн саналыг боловсруулж яаманд хүргэх чиг үүргийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.11-д “тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, хэрэгжилтийг хангах” гэж зааснаас өөр өөр саналыг уламжлах чиг үүргийг хуулиар хүлээлгээгүй байхад дээрх журмаар оногдуулсан гэж үзэхээр байна.

Иргэн, аж ахуйн нэгжийн ирүүлсэн баримт, материалд үнэлгээ хийж, яаманд албан бичгээр саналыг уламжлахдаа хавсралтаар ямар нэгэн баримт бичиг хүргүүлдэггүй, архивын нэгж үүсгээгүй байв. Яамны шийдвэр гарах үед цахим мэдээллийн санд солбицлыг оруулах ажлыг Тусгай хамгаалалттай газрын захиргааны Газар зохион байгуулалт, газрын бүртгэл мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэнд хариуцуулан гүйцэтгүүлж байна.

Журмын нэгд “Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын газрын харилцаатай холбоотой хүсэлтийг судалж, санал дүгнэлт гаргах үүрэгтэй” гэж заасан харилцааг зохицуулсан боловч мөн журмын Ажлын хэсгийн ажиллах журмын ерөнхий чиг үүрэгт “Энэхүү журмын Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаанаас ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглах эрхийг сунгах, цуцлах, хүчингүй болгох, солбицолд өөрчлөлт оруулах, санал болон шүүхийн шийдвэрт биелүүлэх асуудлыг судалж санал, дүгнэлт гаргах ажлыг хэсгийн үйл ажиллагаанд мөрдлөг болгоно” гэж зохицуулж буй харилцаанд хамааралгүй асуудлыг тусгажээ.

Журамд төрийн захиргааны төв байгууллага ямар чиг үүрэг хэрэгжүүлэх, хяналт хэрхэн тавих асуудлыг тусгаагүй орхигдуулсан нь Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 6.1.1-д “Баримт бичгийн шийдвэрлэлтэд тавих хяналт нь баримт бичгийг хяналтад авах, шийдвэрлэлтийн явцад хяналт тавих, шалгах, шийдвэрлэсэн баримт бичгийг хяналтаас хасах, шийдвэрлэлтийн явц, түүний үр дүнг тооцох, мэдээ тайлан гаргах, удирдлагад танилцуулах зэрэг ажилбараас бүрдэнэ” гэсэн заалтыг мөрдлөг болгоогүй байна.

Түүнчлэн журмын гуравт “Ажлын хэсэг нь хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тайлбар авах, материал авах эрхтэй” гэсэн заалтын зохицуулж буй харилцаа нь тодорхойгүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/151 дүгээр “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах, журам батлах тухай” тушаал нь Засгийн газрын 2020 оны



246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7.1-д “Дүрэм, журам, заавар боловсруулахад дараах нийтлэг шаардлагыг мөрдлөг болгоно”, 3.7.1.3-т “бичвэр нь тухайн дүрэм, журам, зааврын агуулгыг илэрхийлэх бөгөөд үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоож, түүнийг зохицуулах, журамлах, мэдээ мэдээллээр хангахад чиглэсэн байна. Бичвэрийг бүлэг, дэд бүлэг, зүйлд хуваан тус бүрийг араб тоогоор дугаарлана. Бичвэрийн заалт бүр нь тодорхой хэм хэмжээ тогтоосон байна” гэж заасныг мөрдөөгүй байгаагаас зохих шаардлагыг бүрэн хангаагүй гэж үзэхээр байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, судалгаа, шинжилгээ хийх ажлын журам батлах, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын хүрээнд явуулж болох үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих зэрэг чиг үүргийг төрийн захиргааны төв байгууллагад олгосон байх тул хамгаалалтын захиргаанаас газар эзэмшигчдийн газрын солбицол нэмэх, хасах үйл ажиллагаанд санал уламжилдаг үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэх нь зүйтэй байна.

--- оОо ---

100